



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Дөргөн сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/104/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Эл би альфа аудит экспэйншин Аудит ХХК

Аудитор: Б.Бадамцэцэг

Утас: 70432545

цахим хаяг: auditbadamaa @ gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. Аудитын илрүүлэлт	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДӨРГӨН СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.МӨНХБАТ ТАНАА

2023.02.17 № 02/51
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Дөргөн сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ховд аймгийн Дөргөн сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Тус сургууль нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан бол тайлант оны эхний 4 сард тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгаас, сүүлийн саруудын санхүүжилтийг улсын төсвөөс авсан онцлогтой байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.7 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

Засгийн Газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон. Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэгдэл урамшууллыг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 2022 онд нийт 602 хүүхэд сургахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 536 хүүхэд сургаж биелэлт 89 хувьтай байна.

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 95 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

021020319

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>92,180,447.17</u>	<u>125,855,302.31</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,710,942.14
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	1,710,942.14
31211	Төрийн сангийн харилцах	-	1,710,942.14
33	АВЛАГА	1,180,000.00	792,863.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,170,000.00	792,863.00
335	Бусад авлага	10,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,000.00	
34	УРЬДЧИЛГАА	13,000,000.00	37,168,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	13,000,000.00	37,168,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	78,000,447.17	86,183,497.17
351	Түүхий эд материал	19,742,283.00	19,742,283.00
35110	Тусгай зориулалттай материал	19,742,283.00	19,742,283.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн		1,094,340.00
354	Хангамжийн материал	58,258,164.17	65,346,874.17
35410	Бичиг хэргийн материал	-	15,500.00
35420	Аж ахуйн материал	54,729,664.17	54,729,664.17
35460	Хүнсний материал	2,739,000.00	9,791,210.00
35470	Бусад хангамжийн материал	789,500.00	810,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,755,402,578.11</u>	<u>2,186,984,742.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,755,402,578.11	2,186,984,742.71
392	Биет хөрөнгө	1,700,277,878.27	2,131,974,292.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,715,438,258.65	2,215,275,161.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,213,417.37)	(188,091,039.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	255,432,362.93	270,742,362.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(204,477,560.33)	(224,125,440.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,716,334.28	128,716,334.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(98,955,336.45)	(106,880,322.41)
39217	Ном	36,337,236.56	36,337,236.56
393	Биет бус хөрөнгө	55,124,699.84	55,010,449.76
39301	Програм хангамж	732,000.00	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(503,500.16)	(617,750.24)

39303	Бусад биет бус хөрөнгө	54,896,200.00	54,896,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,847,583,025.28</u>	<u>2,312,840,045.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>320,900.00</u>	<u>858,721.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	320,900.00	858,721.00
413	Өглөг	320,900.00	858,721.00
4136	Бусад өглөг	320,900.00	858,721.00
41361	Байгууллагад төлөх өглөг	320,900.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	230,000.00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		638,721.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,847,262,125.28</u>	<u>2,311,981,324.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,847,262,125.28	2,311,981,324.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	487,043,343.31	487,043,343.31
51101	Өмч: - төрийн	487,043,343.31	487,043,343.31
512	Хуримтлагдсан үр дүн	529,024,356.04	993,743,554.78
51210	Өмнөх үеийн үр дүн	529,024,356.04	529,024,356.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	464,709,198.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831,194,425.93	831,194,425.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,847,583,025.28</u>	<u>2,312,840,045.02</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

СТА-2

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,098,511,674.24	1,969,495,928.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,909,934.24	489,922,980.44
120	Нийтлэг татварын бус орлого	7,909,934.24	489,922,980.44
120005	түрээсийн орлого	2,631,800.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,278,134.24	489,922,980.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	2,582,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,978,134.24	487,340,980.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,090,601,740.00	1,479,572,948.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	951,586,900.00	1,230,113,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	951,586,900.00	1,230,113,000.00

131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	710,394.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	710,394.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	138,304,446.00	249,459,948.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	530,000.00	1,530,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	116,173,502.00	247,929,948.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	8,000,000.00	
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	13,600,944.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,148,901,452.57	1,504,776,729.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,148,901,452.57	1,504,776,729.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,112,281,584.57	1,443,462,471.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,027,830.00	939,353,971.52
210101	Үндсэн цалин	759,027,830.00	939,353,971.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,047,662.47	117,989,352.62
210201	Тэтгэврийн даатгал	68,370,140.70	79,662,093.12
210202	Тэтгэмжийн даатгал	7,589,155.34	9,147,000.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,071,324.28	7,497,608.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,456,094.75	1,829,400.20
210205	Эрүүл мэндийн даатгал	14,560,947.40	19,853,249.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,764,502.00	194,119,948.00
210301	Гэрэл, цахилгаан	7,360,802.00	7,111,665.00
210302	Түлш, халаалт	105,310,100.00	185,020,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,093,600.00	1,988,283.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,972,054.00	-
210401	Бичиг хэрэг	825,220.00	
210402	Тээвэр, шатахуун	1,849,200.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	374,000.00	

210404	Ном, хэвлэл	2,721,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн урсгал, ариутгал	932,534.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,269,300.00	
2105	Нормативт зардал	44,087,096.00	69,318,190.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,078,800.00	
210502	Хоол, хүнс	39,971,896.00	69,318,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,036,400.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	974,500.00	3,218,550.00
210604	Урсгал засвар	974,500.00	3,218,550.00
2107	Томилолт, зочны зардал	138,000.00	-
210702	Дотоод албан томилолт	138,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,297,000.00	7,087,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	985,000.00	2,582,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,505,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,972,940.10	112,375,459.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,259,303.40	36,032,543.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,750,200.00	5,284,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,963,436.70	71,068,815.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,619,868.00	61,314,258.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,682,019.00	61,314,258.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,081,075.00	61,314,258.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,600,944.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	937,849.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	937,849.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(50,389,778.33)	464,709,198.74
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(50,389,778.33)	464,709,198.74

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	487,043,343.31	831,194,425.93	529,024,356.04	1,847,262,125.28
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	487,043,343.31	831,194,425.93	529,024,356.04	1,847,262,125.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	487,043,343.31	831,194,425.93	529,024,356.04	1,847,262,125.28
D08	Тайлант үеийн үр дүн			464,709,198.74	464,709,198.74
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	487,043,343.31	831,194,425.93	993,733,554.78	2,311,971,324.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,096,752,090.40	1,482,154,948.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,150,350.40	2,582,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,150,350.40	2,582,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	2,582,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,582,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	
120005	Түрээсийн орлого	2,631,800.00	
120009	Бусад орлого	3,218,550.40	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,090,601,740.00	1,479,572,948.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	951,586,900.00	1,230,113,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	951,586,900.00	1,230,113,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	710,394.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	710,394.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,703,502.00	249,459,948.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,530,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	530,000.00	
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	116,173,502.00	247,929,948.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	8,000,000.00	
133006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	13,600,944.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,096,752,090.40	1,483,865,890.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,096,752,090.40	1,483,865,890.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,054,160,322.40	1,433,458,407.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин	756,271,100.00	939,247,309.86
210102	Нэмэгдэл	525,445,331.00	612,541,423.93
210104	Урамшуулал	189,488,713.00	277,995,714.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,096,800.00	117,680,600.00
210201	Тэтгэврийн даатгал	71,845,800.00	80,094,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,562,800.00	9,333,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,050,200.00	7,522,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,461,200.00	1,884,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,176,800.00	18,845,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,855,102.00	195,536,448.00
210301	Гэрэл, цахилгаан	7,733,402.00	7,742,165.00
210302	Түлш, халаалт	105,310,100.00	185,020,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,811,600.00	2,774,283.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,949,354.00	2,582,000.00
210401	Бичиг хэрэг	800,020.00	
210402	Тээвэр, шатахуун	1,790,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	374,000.00	
210404	Ном, хэвлэл	2,867,400.00	2,582,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,149,234.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	968,700.00	
2105	Нормативт зардал	40,016,516.00	88,958,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,599,900.00	
210502	Хоол, хүнс	34,815,616.00	88,958,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,601,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,073,400.00	4,291,900.00

210604	Урсгал засвар	1,073,400.00	4,291,900.00
2107	Томилолт, зочны зардал	138,000.00	-
210702	Дотоод албан томилолт	138,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,720,000.00	10,384,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	2,582,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		7,802,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,040,050.40	74,777,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,066,650.40	62,357,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,973,400.00	12,419,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,591,768.00	50,407,482.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,653,919.00	50,407,482.28
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,052,975.00	50,407,482.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,600,944.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	937,849.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	937,849.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	(1,710,942.14)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(1,710,942.14)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,710,942.14

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1482226900.00	1484592705.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1482226900.00	1484592705.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1419945800.00	1422311907.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	934089600.00	939247309.86
210101	Үндсэн цалин	707950800.00	612541423.93
210102	Нэмэгдэл	196828300.00	277995714.19
210104	Урамшуулал	29310500.00	48710171.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116655800.00	117680600.00
210201	Тэтгэврийн даатгал	79397700.00	80094600.00
210202	Тэтгэмжийн даатгал	9251100.00	9333100.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	7456900.00	7522500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1868300.00	1884700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18681800.00	18845700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	198351400.00	195536448.00
210301	Гэрэл, цахилгаан	8456000.00	7742165.00
210302	Түлш, халаалт	186695400.00	185020000.00
210303	Цэвэр, бохир ус	3200000.00	2774283.00
2105	Нормативт зардал	76,245,600.00	76,245,600.00
210502	Хоол, хүнс	76,245,600.00	76,245,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,291,900.00	4,291,900.00
210604	Урсгал засвар	4,291,900.00	4,291,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,879,500.00	10,384,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,582,000.00	2,582,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,297,500.00	7,802,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,432,000.00	78,925,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,985,700.00	66,596,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,446,300.00	12,329,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,281,100.00	62,280,798.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,281,100.00	62,280,798.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,281,100.00	62,280,798.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,478,042,948.00	1,478,042,948.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,230,113,000.00	1,230,113,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,230,113,000.00	1,230,113,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	247,929,948.00	247,929,948.00
132001	Орон нутгийн төсвөөс		
132003	төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	247,929,948.00	247,929,948.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,710,942.14
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64.00	64.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	569.00	536.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	569.00	536.00
630001	Төрийн өмчит ЕБС	569.00	536.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	64.00	64.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	42.00	42.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	21.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дөргөн сумын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд багш сурагчдын тасралтгүй хөгжих нөхцөлийг сайжруулан, олон нийтийн оролцоотойгоор тогтвортой хөгжлийг дэмжиж, агуулгын хоцрогдлыг нөхөн, хүүхэд бүрийн хөгжил төлөвшил, сурлагын амжилтад ахиц гаргах үндсэн зорилготойгоор захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, эмч 1, үндсэн багш 35, туслах 21 нийт 61 ажилтан албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулсан байна.

Танхимаар тасралтгүй 33-34 долоо хоног хичээллэж, сургуульд суурилсан үнэлгээ улсын хэмжээнд анх удаа хийгдэж 10 багшийн заасан хичээл I-III түвшинд үнэлэгдэж сарын 10%-25% урамшуулал авсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал;
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам” БСШУЯ-ны А/59 тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж ажиллаж байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дөргөн сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 431,6 сая төгрөгөөр букуу 1.18 хувиар өссөн байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данстын үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1.7	1.7
Авлага	14.2	38.0	23.8
Бараа материал	78.0	86.2	8.2
Үндсэн хөрөнгө	1,755.4	2,187.0	431.6
Нийт хөрөнгө	1,847.6	2,312.9	465.3
Өр төлбөр	0.3	0.9	0.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,847.3	2,312.0	464.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,847.6	2,312.9	465.3

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ "Техно Зон" компаниас 37.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийсэн боловч гэрээний хугацаа дууссан, хөрөнгө бодитоор ирээгүй байгааг НББ-д авлагаар бүртгэсэн.
- ✓ Дөргөн сумын ЗДТГ-аас хичээлийн 3-р байр болгон 487,0 сая төгрөгийн өртөгтэй 12,4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй барилгыг данснаас дансанд шилжүүлэн өгснийг НББ-д үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.
- ✓ 2021 онд авлагаар тайлагнасан 13.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг авч НББ-д үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,230.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 253.1 сая төгрөг, зарлагыг 1.483.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсролын салбар нь үр дүн гүйцэтгэлд суурилсан төсвөөр төсвөө боловсруулснаар тайлант оны батлагдсан төсвийг 5.1 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,230.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 247.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,230.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 247.9 сая төгрөг, нийт 1,478.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, 1.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,476.3 сая төгрөг буюу 99.0 хувьтай байгаа тогтмол зардлыг 1.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Ерөнхий боловсрол -71802				
1	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	202.6	199.8	2.8	99
2	Нийтлэг үйлчилгээ-80112	50.4	48.1	2.3	95
3	Байр ашиглалтын үйлчилгээ-80226	3.3	3.3	-	100
4	Сургалт семинар-80312	1.6	1.6	-	100
5	Эрүүл мэндийг дэмжих-81605	3.8	3.8	-	100
6	Үдийн цай-81801	62.3	62.3	-	100
7	Дотуур байрны үйлчилгээ-81806	128.4	128.4	-	100
8	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816	37.5	37.4	0.1	100
9	Боловсролын байгууллагын багш-81823	7.5	7.5	-	100
10	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөр-81834	876.6	876.6	-	100
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835	109.1	109.1	-	100
12	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн-81844	0.3	0.3	-	100
13	Сурах бичгийн түрээс-81848	2.6	2.6	-	100
14	ЗГ болон нөөц хөрөнгөөс хуваарилсан-83602	1.5	1.5	-	100

ДҮН	1,487.5	1,482.3	5.2	99.0
-----	---------	---------	-----	------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Дөргөн сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эл би альфа экспэйншин аудит ХХК-ны аудитор Б.Бадамцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Дөргөн сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,146.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.2 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт 1,500,7 сая төгрөгөөр 1,5 хувиар буюу 22.5 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 18.0 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын төсвөөс 5.1 сая төгрөгийн зардлыг хасаж тодотгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын 143 гүйлгээг бүрэн мэдээлж хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн

нэгдсэн системд бүртгүүлэн гүйлгээ хийсэн боловч ААН-ийн нэрээр гүйлгээ хийсэн боловч хувь хүнээс И баримт бүртгүүлсэн тохиолдол байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч 106.6 сая төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснээс 1 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх заалт бүхий зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Аудитын шийдвэрийн нийт биелэлт 85 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	106637.2	1	106637.2	85
Нийт дүн	2	106637.2	1	106637.2	85

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бүх албан хаагчдын ээлжийн амралтын цалинг, хүүхдийн үдийн цай, дотуур байрны хоолны зардлыг тайлагнахдаа няравын тайлан гаргалт хангалтгүй, хүүхдийн тоог батлахдаа хянадаггүй дутагдал байгааг дахин хянаж үзэх, бараа материалын тооллогыг чанартай хийж байхыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа¹, санхүүгийн тайланд алдаатай илэрхийлсэн 11.8 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж зөрчлийг арилгуулсан.

Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
- ✓ Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг 3,0 сая төгрөгөөр илүү тайлагнасан, үр дүнгийн тайланд бусад орлогыг 5.8 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв, гаргах үндэслэл болно",
- ✓ Хуримтлагдсан үр дүнг буруу илэрхийлсэн 1.3 сая төгрөгийг залруулсан нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.76-д "орлого, зарлагын нэгдсэн зөрүүгээр тайлангийн үеийн үр дүнг тодорхойлно",
- ✓ 8-р сард олгосон амралтын мөнгөнөөс даатгуулагчийн төлөх НДШ-ийг суутгасан боловч НД-ын тайланд тусгаж тайлагнаагүй 0,63 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй, мөн хамтын сангийн хуримтлал болох 0.23 сая төгрөгийг суутгасан боловч дутуу шилжүүлснийг өглөгөөр тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", НДШ, ХХОАТ, ҮЭ-ийн татваруудын тооцоо нийлж баталгаажуулаагүй, илүү төлөлтийг авлагаар санхүүгийн тайланд тайлагнаагүй 0.8 сая төгрөг нийт 11.8 сая төгрөгийг залруулж авлагаар тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг,

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 15.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 заалт бүхий зөвлөмж, 11.8 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

5.1 Төлбөрийн акт

- ✓ Амралтын цалин, үндсэн цалинг давхардуулан 0.6 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ур чадварын нэмэгдлийг холбогдох албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 0.4 сая төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 5.4-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолын 4-р хавсралтын 3-д "... Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно гэсэн заалттай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ ҮЭ-ийн татварыг суутгасан дүнгээс 0.4 сая төгрөгийг илүү төсвөөс төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Томилолтын зардлыг 0.05 сая төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичээгүй болно.

5.3 Зөвлөмж

5.3.1 Зардлын данстай холбоотой

- ✓ **Илрүүлэлт:** Шатахууны тайлан гаргаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, замын хуудас дутуу, олгосон зориулалт тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэл дутуу, хяналтгүй 2.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Анхан шатны баримтыг бүрдүүлж, тайлан гаргаж, тооцоо бодож хэвших, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

5.3.2 Зардалтай холбоотой

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны тооцоо бодоогүй, няравын гаргасан тайлан зөрүүтэй хүүхдийн хоолны толан дутуу бичигдсэн, тааруулж тайлагнадаг зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана", 5.1.3- д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв, гаргах үндэслэл болно" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулж, норм нормативийг зохих журмын дагуу хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд болон үр дүнгийн тайланд орлого санхүүжилтийг илүү тайлагнасан, хуримтлагдсан үр дүнг буруу илэрхийлсэн	3.0	10.1	-	-	3.0	10.1	3.0	10.1	-	-	-	-
Авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, тооцоогоо бүрэн хийж өглөгөөр тайлагнаагүй зөрчил илэрлээ.	2.0	0.9			2.0	0.9	2.0	0.9				
Ц.Мөнхбатын 8-р сарын амралтын цалингаас даатгуулагчийн НДШ-ийг суутгасан боловч тайлагнаж төлөөгүй, өглөгөөр тайлагнаагүй	1.0	0.8			1.0	0.8	1.0	0.8				
Дүн	6.0	11.8	-	-	6.0	11.8	6.0	11.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Амралт, цалин давхардуулан илүү олгосон	2	1.0	2	1.0				-
Шатахууны замын хуудас хөтлөөгүй	1	2.2					1	2.2
Томилолт илүү олгосон	1	0.05	1	0.05				
Төсвөөс илүү шилжүүлсэн	1	0.4	1	0.4				
Үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны тооцоо бодоогүй, няравын гаргасан тайлан зөрүүтэй хүүхдийн хоолны толан дутуу бичигдсэн, тааруулж тайлагнадаг зөрчил илэрлээ.	1						1	
Дүн	6	3.7	4	1.5	-	-	2	2.20

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.БАДАМЦЭЦЭГ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 66/А 2160424

Ховд

ХОА-2022/105/НА/СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дөргөн сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд ажилчдад ээлжийн амралтын цалинг илүү олгосон, ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр олгосон, төсвөөс суутгасан дүнгээс илүү дүнгээр шилжүүлсэн, томилолтын хоног илүү олгосон нийт 1514913 төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсантай холбоотой 1514913 /Нэг сая таван зуун арван дөрвөн мянга есөн зуун арван гурван төгрөг/ -ийг Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх.
2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дөргөн сумын ЕБС-ийн захирал Б.Мөнхбат, нягтлан бодогч О.Балжинням нарт тус тус хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Д.НАРАНТУУЛ